In the old days the *гер* had an open hearth (*гал голомт*) crafted from iron by a local blacksmith (*дархан*), and the hearth is the symbol of Mongol tradition; the youngest son was the guardian of the hearth, that is, the home territory.

There are various constructions to do with fire: *гал авах* 'to catch fire', *гал түлэх* 'to fuel (feed) a fire', *гал гаргах* 'to make a fire'; one can also say *гал галлах* 'to make a fire', but this also means 'to shoot', and *гал нээх* is 'to open fire'.

НЭМЭЛТ ҮГ

Additional vocabulary

With their orientation towards traditional practices and the natural cycle of animal life, country folk have different household equipment and foodstuffs from their town cousins. The herdsman's basic equipment is for horse management:

| | | | |
|--------|--------|-------|---------------|
| хазаар | bridle | уяа | hitching line |
| чөдөр | hobble | уурга | lasso pole |
| эмээл | saddle | дөрөө | stirrup |
| ташуур | whip | | |

The nomad's main summer food, or *цагаан идээ* as it is called, consists of a variety of home dairy produce:

| | | | |
|--------|------------|--------|----------------|
| ааруул | dried curd | аарц | sour milk curd |
| бяслаг | cheese | өрөм | clotted cream |
| тараг | sour milk | тос(н) | butter |
| цоцгий | cream | | |

Several other kinds of homemade food are also a regular feature of *гер* life:

| | | | |
|------|---------------------------------|---------|-----------------------|
| банш | boiled meat dumplings for soups | | |
| боов | fried pastry | борц | air-dried meat strips |
| бууз | steamed meat dumplings | хуушуур | fried meat dumplings |

Other points

The names of the seasons, like 'yesterday' or 'today', are used without case suffixes: *зун* means 'summer' or 'in summer'.

The Mongols use the term *таван хошуу мал* 'five kinds of livestock' to describe their main flocks and herds (*хошуу* actually means 'muzzle').

Mongol guard dogs can be fierce, and it is a wise precaution to get the owner to tie them up before you get out of the car – hence the call *Нохойгоо хорь* or *Нохой хорио!*

Exercise 4

Translate into Mongolian:

- I have only two children.
- Delgermaa has almost ten dogs.
- Bat has only about 70 cows.
- Tömör has fewer than 30 sheep.
- Mongolia has more than 29 million livestock.

Exercise 5

Translate into English:

- Морь, тэмээ, хонь, ямаа, үхрийг таван хошуу мал гэдэг.
- Морь, хонийг халуун хошуутай мал гэдэг.
- Үхэр, тэмээ, ямааг хүйтэн хошуутай мал гэдэг.

- 4 Гахай, тахиа хоёр таван хошуу малд ордоггүй.
5 Таван хошуу малын алинаас нь ноолуур гардаг вэ?

Exercise 6

Identify these ten articles and list them in Mongolian as (a) *herding* equipment or (b) *herding* equipment:

хазаар, яндан, багана, уурга, хөхүүр, тооно, эмээл, ташуур,
чөдөр, хана

Dialogue 3

Малаар баян, мөнгөөр ядуу
Rich in livestock, poor in cash

David and Julie continue their chat with herdsman Baljinnyam and discuss some of the hardships of country life.

- Девид: Та ямар жилтэй вэ?
Балжинням: Би морьтой. Хаврын тэргүүн сард төрсөн. Миний эхнэр нохойтой. Гурван ихэр хүүхэд үхэртэй.
Жюли: Олуулаа болохоор их мөнгө орно биз?
Девид: Та сард ямар цалинтай вэ?
Балжинням: Би цалингүй. Би малчин хүн, ардын аж ахуйтан. Малаар баян гэвч мөнгөөр ядуухан хүн байна.
Жюли: Өвөрхангай аймагт нэг морь ямар үнэтэй вэ?
Балжинням: Нэг морь зургаан хоньтой тэнцэнэ. Нэгдлийн гишүүн байхдаа бага цалин авч байсан боловч одоо гурван жил надад ямар ч мөнгө байхгүй байна. Харин шагналын мөнгө нэг удаа авсан!
Девид: Тийм үү? Ямар шагнал?
Балжинням: Би тэргүүний малчин цолтой, бас 93 онд Монгол Улсын Ерөнхийлөгч намайг «Алтан гадас» одонгоор шагнасан. Танд Ерөнхийлөгчийн зарлиг үзүүлье?
Жюли: Алив тэгээч. Зарлигт тань юу гэж бичсэн байна?
Балжинням: Зарлигт, мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан Даваажавын Балжиннямыг Алтан гадас одонгоор шагнасугай гэж бичээд.
Жюли: Гэргий тань юу гэсэн гэлээ?

- Балжинням: Эхнэр зарлигийг радиогоор сонсонгуут надад нэг хачин үг хэллээ: «Ус уухгүй үхрийн толгойг бүү дар, үг мэдэхгүй хүний толгойг бүү илбэ» гэж.
DAVID: *What year were you born in?*
BALJINNYAM: *I was born in the horse year, in the first month of spring. My wife was born in the dog year. The triplets are 'oxen'.*
JULIE: *Since there are many of you it must cost a lot surely?*
DAVID: *What's your monthly salary?*
BALJINNYAM: *I don't have a salary. I am a herdsman, an independent herder. I am rich in livestock but I am quite a poor man in money terms.*
JULIE: *How much is a horse worth in Övörkhongai province?*
BALJINNYAM: *A horse is worth six sheep. Although I used to get a small wage when I was a negdel member I have now had no money for three years. But I did get some prize money once!*
DAVID: *Really? What prize?*
BALJINNYAM: *I have the title 'front-ranking' herdsman, and in 1993 the Mongolian President awarded me the Order of the Pole Star. Let me show you the president's decree.*
JULIE: *Please do! What does your decree say?*
BALJINNYAM: *The decree says that for making an important contribution to the development of livestock production Davaajavyn Baljinnyam is to be awarded the Order of the Pole Star.*
JULIE: *What did your wife say?*
BALJINNYAM: *As soon as she heard the decree on the radio the wife said to me something strange: 'You can lead a horse to water ...'*

Notes: The proverb in full says: 'Don't press the head of an ox that doesn't drink, don't stroke the head of a man that doesn't know.'

The *negdel* or herding cooperatives were the basic structure for collective animal husbandry from the 1950s until they were disbanded in the 1990s. The independent herders are **ардын аж ахуйтан** or 'people's enterprise persons'. The Order of the Pole Star (**Алтан гадас**, the 'golden stake') is one of Mongolia's top awards for services to the state.

ШИНЭ ҮГ Vocabulary

| | | | |
|-------------|-------------------|-------------|----------------|
| аж ахуй | enterprise | орох | to cost |
| мал аж ахуй | livestock herding | тэргүүн(ий) | leading; first |
| баян | rich | үйлдвэрлэл | production |
| гадас(н) | stake, pole | хачин | strange, funny |
| дарах | to press | хөгжүүлэх | to develop |
| зарлиг | decree | хувь нэмэр | contribution |
| илбэх | to stroke | цалин(г) | wage, salary |
| ихэр | twins | цол | title |
| гурван ихэр | triplets | чухал | important |
| нэгдэл | cooperative | шагнал | award |
| одон(г) | order | ядуу | poor |

Language points

Animal calendar

The dialogue begins with a short exchange about the years of birth of Baljinnyam and his wife, using the traditional animal names. Colloquially you say the year's animal name in the comitative case: **Би морьтой**. 'I horse-with', 'I was born in the horse year.' The twelve years in the usual order, with the current equivalents, are as follows:

| | | |
|-------------|---------------|--------|
| хулгана жил | mouse | 1996/7 |
| үхэр жил | ox (cow) | 1997/8 |
| бар жил | tiger | 1998/9 |
| туулай жил | hare | 1999/0 |
| луу жил | dragon | 2000/1 |
| могой жил | snake | 2001/2 |
| морин жил | horse | 2002/3 |
| хонин жил | sheep (ewe) | 2003/4 |
| мичин жил | monkey | 2004/5 |
| тахиа жил | chicken (hen) | 2005/6 |
| нохой жил | dog | 2006/7 |
| гахай жил | pig (sow) | 2007/8 |

The calendar is the lunar calendar, and the year changes with the new moon in late January or early February and is celebrated in a festival called **цагаан сар**.

The twelve animal years are combined with five elements (**махбод**), each having its own colour. Each element and colour prevails for two years, the colour names having in the first year the usual forms and in the second year forms used to describe female animals (in brackets):

| | | | |
|--------|-------|--------|---------------------------|
| мод | wood | blue | хөх (хөхөгчин) |
| гал | fire | red | улаан (улаагчин) |
| шороон | earth | yellow | шар (шарагчин) |
| төмөр | iron | white | цагаан (цагаагчин) |
| усан | water | black | хар (харагчин) |

This suggests that the years are alternately male and female or perhaps the animals, although this is disputed. There are special nouns in current use for many female animals, including **үнээ** 'cow' and **гүү** 'mare', but not e.g. for 'ewe', **эм хонь**.

The animals are usually referred to by the element in 'male' years and by the colour in 'female' years: 1996/7 is 'fire mouse' year, 1997/8 'red cow' year, 1998/9 'earth tiger' year, and so on (for further details see Grammar summary).

The animals and elements combined create a cycle of 60 years (12 × 5) before the combinations begin to repeat themselves. This cycle is called a **жаран** '60'. The first **жаран** began in 1027, and the current one (XV) in 1987 (year of the hare).

Note that when used attributively nouns with fleeting n display it: **морин жил, хонин жил, мичин жил, модон махбод, усан махбод**.

Traditional names for months

The traditional names for the months are also in use with the lunar calendar. They are in sequence the 'leading', **тэргүүн**, 'middle', **дунд** and 'end', **адаг** months of 'spring' (**хавар**), 'summer' (**зун**), 'autumn' (**намар**) and 'winter' (**өвөл**) respectively:

| | |
|--------------------|--------------------|
| хаврын тэргүүн сар | зуны тэргүүн сар |
| хаврын дунд сар | зуны дунд сар |
| хаврын адаг сар | зуны адаг сар |
| намрын тэргүүн сар | өвлийн тэргүүн сар |
| намрын дунд сар | өвлийн дунд сар |
| намрын адаг сар | өвлийн адаг сар |

The names of the days of these months also relate to the animal cycle, as do the traditional hours of the day (see page 242).

Successive converb (as soon as) -нгуут

Baljinnyam says that 'as soon as his wife heard the decree on the radio' (зарлигийг радиогоор сонсонгуут) she cited a proverb. Here are some more examples of what is called the successive converb (stem plus -нгуут/-нгүүт):

Аавыг явангуут ээж ирлээ.

As soon as (my) father had gone (my) mother arrived.

The successive converb can also attract the reflexive suffix when the subjects are the same:

Ирэнгүүт нь над хэлээрэй.

Tell me as soon as he arrives.

Ирэнгүүтээ над хэлээрэй.

Tell me as soon as you arrive.

'Let it be so'

Resolutions, decrees and other official decisions add to the verb stem the voluntative suffix -сугай, -сүгэй 'Let us ...'. The form is active, but translates better as passive 'X is to be ...':

Д. Балжиннямьг Алтан гадас одонгоор шагнасугай.

Let us award D. Baljinnyam the Order of the Pole Star.

D. Baljinnyam is to be awarded the Order of the Pole Star.

Further examples (see below the presidential decrees on ambassadors) include үүрэгт ажлаас чөлөөлсүгэй 'is to be released from (his) duties' from the verb чөлөөлөх and томилсугай 'is to be appointed' from томилох.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1997 оны 3 дүгээр Дугаар 46 Улаанбаатар
сарын 24-ний өдөр хот

**Цэдэнжавын Сүхбаатарыг элчин
сайдаар томилох тухай**

Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант
Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар
Цэдэнжавын Сүхбаатарыг тохоон томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ П. ОЧИРБАТ

Нэгдсэн Вант Улс
Онц бөгөөд Бүрэн эрхт
элчин сайд

United Kingdom
Ambassador Extraordinary and
Plenipotentiary

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1993 оны 1 дүгээр Дугаар 5 Улаанбаатар
сарын 13-ны өдөр хот

**ЗАРИМ ХҮНИЙГ ОДОН, МЕДАЛИАР
ШАГНАХ ТУХАЙ**

Мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чухал хувь
нэмэр оруулж, өндөр ашиг шимтэй шинэ үүлдрийн мал
бий болгоход хөдөлмөрийн амжилт гаргасныг үнэлж дор
дурдсан хүмүүсийг Монгол Улсын одон медалиар
шагнасугай.

Сүхбаатарын одонгоор:

Самбуугийн Дугаржав – Мал аж ахуйн эрдэм шинж-
илгээний хүрээлэнгийн
секторын эрхлэгч

Алтан гадас одонгоор:

Даваажавын Балжинням – Өвөрхангай аймгийн
Шанх сумын малчин

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ П. ОЧИРБАТ

Нэмэлт Үг**Additional vocabulary**

| | | | |
|-------------|----------------|-----------------|----------------|
| амжилт | success | сум | rural district |
| ашиг шим | productivity | үнэлэх | to appreciate |
| ашиглах | to make use of | үүлдэр | breed |
| бий болгох | to create | хүрээлэн | institute |
| дор дурдсан | undermentioned | шинэ | new |
| зарим | certain, some | эрдэм шинжилгээ | research |
| медаль | medal | | |

Exercise 7

Translate into English:

- 1 Ерөнхий сайдын үүрэгт ажлаас Пунцагийн Жасрайг чөлөөлсүгэй.
- 2 Утсыг дуугарангуут Сүх очиж авсан.
- 3 Энэ зарлигийг хүчингүй болгосугай.
- 4 Батыг зогсоол хүрэнгүүт ямаан тэрэг ирсэн.
- 5 «Сонгино» дүүрэг гэснийг «Сонгино хайрхан» дүүрэг гэж өөрчилсүгэй.

Exercise 8

Translate into English the text of the decree No 5. on page 157.

Exercise 9

Match the animal years and elements, e.g. 1997/8 = red (fire) ox:

- | | |
|----------|----------|
| 1 2003/4 | 2 2007/8 |
| 3 2000/1 | 4 2005/6 |
| 5 2002/3 | |

Dialogue for comprehension 7 

- Девид: Өнөөдөр тэнгэр ямар байна?
 Жюли: Тэнгэр сайхан байна. Монголд жилийн ихэнх өдөр тэнгэр цэлмэг байдаг. Тэгээд Монголыг хөх тэнгэрийн орон гэдэг юм!
- Девид: Маргааш ямар байх бол?
 Жюли: Тэнгэр муухайрна гэсэн. Дуутай бороо орох гэнэ.
- Девид: Нөгөөдөр тэнгэр арилах болов уу?
 Жюли: Магадгүй. Хүйтэн өвөл болох шинжтэй. Гэрт өвөл дулаахан байдаг уу?
- Балжинням: Өвөл гурван давхар бүрдэг юм.
 Девид: Гэрт ямар халаалгатай байдаг вэ?
 Малчны эхнэр Мөнхөө: Зуухыг аргал түлшээр халаадаг юм.
- Девид: Та хэдэн малтай вэ?
 Балжинням: Би хоёр зуугаад хонь, ная шахам ямаа, аравхан үнээ, таван морьтой. Надад тэмээ байхгүй.
- Девид: Та ямар жилтэй вэ?

- Балжинням: Би хулганатай. Миний эхнэр бартай.
 Жюли: Та хэдэн хүүхэдтэй вэ?
 Мөнхөө: Долоохон.
 Жюли: Есүүлээ болохоор их мөнгө оролгүй яах вэ?
 Балжинням: Малаар баян боловч мөнгөөр ядуу байна. Харин би тэргүүний малчин. Монгол Улсын Ерөнхийлөгч намайг медалиар шагнасан.
- Жюли: Гэргий тэнь юу гэсэн гэлээ?
 Балжинням: Эхнэр надад, ус уухгүй үхрийн толгойг бүү дар, үг мэдэхгүй хүний толгойг бүү илбэ гэж хэлсэн.

Note: Not all Mongols accept a front-vowel version **тэнь** of the word **тань**.

8 Долоо хэмжиж нэг огтол

Look before you leap

In this lesson you will learn:

- About shopping in shops and markets
- Verb forms for 'when' and 'while'
- Admonitory verb form (don't forget!)
- How to say 'shouldn't'
- Russian words in everyday use

Dialogue 1

Манайхаар дахиад үйлчлүүлээрэй!

Please call again!

Bat and Delgermaa are out shopping and decide to try a new grocery store.

- Дэлгэрмаа: Шинэ шөнийн дэлгүүр явах уу?
 Бат: Шөнийн дэлгүүрээ? Юу вэ?
 Дэлгэрмаа: Шөнийн дэлгүүр гэдэг бол хорин дөрвөн цагийн ажиллагаатай хүнсний дэлгүүр.
 Бат: За хоёулаа юу юу авах билээ?
 Дэлгэрмаа: Бидэнд авах юмны жагсаалт байгаа.
 Бат: Өө зүйтэй. Би хараадахъя. Байхуу цай, будаа, жаахан үхрийн мах, төмс, лууван, байцаа, тараг гэж байна. Аа бас жаран лааны чийдэнгийн шил нэг хэрэгтэй юм байна. Манай жорлонгийн гэрэл шатчихсан.
 Дэлгэрмаа: Чи ундаа, уух юмаа бичихээ мартсан байна.
 Бат: За нэг шил «Бага банди» архи, нэг шил цагаан дарс, дөрвөн сав рашаан ус авъя. Манайд талх бий юу?

- Дэлгэрмаа: Бий, бий. Өчигдөрийн талх дуусаагүй байсан. Харин нэг кило сайхан гадил нэмж авъя.
 Бат: Тэгье, тэгье. Гадил их үнэтэй байна шүү. Нэг кило нь нэг мянга дөрвөн зуун төгрөг гэж байна.
 Дэлгэрмаа: За одоо хоёулаа касс руу очиж бичүүлье. Хэдэн төгрөг болж байгаа бол?
 Кассчин: Зургаан мянга найман зуун дөчин төгрөг.
 Бат: За баярлалаа! Баяртай!
 Кассчин: Баяртай! Манайхаар дахиад үйлчлүүлээрэй!
- DELGERMAA: *Shall we go to the new night shop?*
 БАТ: *Night shop? What's that?*
 DELGERMAA: *The night shop is a grocery store (food shop) which works 24 hours.*
 БАТ: *So what are the two of us going to buy?*
 DELGERMAA: *We do have a shopping list.*
 БАТ: *Oh right! Let me take a look. It says black tea, rice, some beef, potatoes, carrots, cabbage, and sour cream. Ah, and (we) need a 60-watt light bulb. The light in our lavatory has burned out.*
 DELGERMAA: *You forgot to write down the drinks.*
 БАТ: *Well, a bottle of 'Baga bandi' vodka, a bottle of white wine and four bottles of mineral water. Do we have any bread?*
 DELGERMAA: *Yes, yes. Yesterday's hasn't been finished. But let's add a kilo of nice bananas.*
 БАТ: *OK, OK. Bananas are certainly expensive. One kilo (of them) is 1,400 tugriks.*
 DELGERMAA: *So now let's the two of us go to the cashier (checkout) and get our bill. How much (many tugriks) might that be?*
 CASHIER: *6,840.*
 БАТ: *Thank you. Goodbye.*
 CASHIER: *Goodbye. Please call again (lit. be served by us again).*

Шинэ Үг Vocabulary

| | | | |
|-----------|-------------------|----------|-------------------|
| ажиллагаа | activity | бичүүлэх | to get one's bill |
| байхуу | black (pekoe) tea | гадил | banana |

| | | | |
|----------|----------------|----------------|-------------|
| жагсаалт | list | үнэтэй | expensive |
| зүйтэй | right, correct | хүнс(н) | foodstuffs |
| лаа | candle; watt | чийдэн(г) | lamp |
| сав(н) | container | чийдэнгийн шил | light bulb |
| талх(н) | bread | шатах | to burn out |

Language points

Voluntative for short actions

Bat says, **Би хараадахъя** 'Let me take a look.' This first-person voluntative form used for short actions is constructed with the derivational suffixes **-аадах-** (**-оодох-/өөдөх-/ээдэх-**) plus the voluntative suffixes giving **-аадах-ъя** (**-оодох-ъя/өөдөх-ъя/ээдэх-ья**) added to the verb stem (in this case **хар** from **харах**):

Би бичээдэхье. Let me jot it down. (from **бичих**)

Би ороодохье. Let me pop in. (from **орох**)

Imperative for short actions

For short actions, as with the voluntative forms above, there are three second-person imperatives:

-аадах (**-оодох, -өөдөх, -ээдэх**) the stem imperative

-аадахаач (**-оодохооч, -өөдөхөөч, -ээдэхээч**) the polite **-аач**

-аадахаарай (**-оодохоорой, -өөдөхөөрэй, -ээдхээрэй**) the future imperative **-аарай**:

Хар! Хараадах!

Хараач! Хараадахаач!

Хараарай! Хараадахаарай! Take a look! (from **харах**)

Бич! Бичээдэх!

Бичээч! Бичээдэхээч!

Бичээрэй! Бичээдэхээрэй! Jot it down! (from **бичих**)

Causative verbs

The verbs **бичүүлэх** and **үйлчлүүлэх** are causative verbs based respectively on **бичих** 'to write' and **үйлчлэх** 'to serve': to have someone write something (i.e. the bill), and to have someone serve someone (i.e. the shopper).

Delgermaa says,

За одоо хоёулаа касс руу очиж бичүүлье.

So now let the two of us visiting the cashier have (the bill) written out.

In turn the cashier thanks her and says,

Манайхаар дахиад үйлчлүүлээрэй.

Please have yourselves served by our people again.

Intensive verbs

The perfective verbal noun **шатчихсан** is derived from **шатах** 'to burn out', 'burn up' by insertion of the derivational suffix **-чих-** (describing a sudden or unexpected action, see page 87):

Шатчихсан байна. It's burned out.

There is a similar form based on the perfective converb:

Батыг ирэхэд шатчихаад байсан.

When Bat arrived it was (had) burned out.

Other points

The word **бичихээ** used by Delgermaa is the present-future verbal noun **бичих** plus the reflexive (accusative) ending **-ээ**: 'You have forgotten your writing of the drinks' **ундаа уух юмаа** being also with reflexive **-аа**.

As indicated by the final **бол** Delgermaa's question to the cashier is rather tentative (see page 118): ... **болж байгаа бол?** '(How much) might that be?'

Exercise 1

Translate into Mongolian:

- 1 Potatoes are not expensive. They are T500 for half a kilo.
- 2 Do we have any bread? No. Yesterday's bread is finished.
- 3 Where is the checkout? Let's go and pay.
- 4 How much would that be, T8,743?
- 5 How many dollars is that? T8,743 is about 11 dollars.

Exercise 2

Give the 'short-action' voluntative and imperative forms for the following:

- 1 Let's find out! Find out!
- 2 Let's go! Go!
- 3 Let's pop in! Pop in!
- 4 Let's take! Take!
- 5 Let's give! Give!

Exercise 3

Reorganize your shopping list to separate foodstuffs from other purchases:

чийдэнгийн шил, талх, залгуур, жүрж, лавлах бичиг, жорлонгийн цаас, байцаа, хайч, хонины мах, төмс, тавиур, ааруул, харандаа, архи, цай

Dialogue 2 

Дэлгүүрээс арай хямдхан уу?

Is it a bit cheaper than the shop?

Bat and Delgermaa talk to Julie and David about going to the market.

Дэлгэрмаа: Улаанбаатарт нэг үеэ бодвол хүнсний хангамж их сайн болжээ. Одоо юу л бол юу авч болохоор байна.

Жюли: Хамгийн сайн хүнсний зах аль нь вэ?

Бат: Улаанбаатарт «Дөрвөн уул», «Далай ээж», «Хар хорин», гээд олон хүнсний зах бий. Харин «Далай ээж» захыг хамгийн сайн нь гэдэг юм.

Девид: «Далай ээж» зах хаана байдаг вэ?

Дэлгэрмаа: «Далай ээж» зах улсын их дэлгүүрээс урагшаа, улсын циркийн баруун талд байдаг.

Жюли: Яагаад энэ зах сайн гэж?

Бат: Улаанбаатарт амьдардаг гадаадынхан энэ зах руу очих, тэндээс хүнсний бараагаа авах их дуртай. Учир нь хүнсний барааны сонголт сайтай. Жишээлбэл янз бүрийн махан, сүүн бүтээг-

дэхүүн, жимс, ногоо, олон төрлийн чихэр, жигнэмэгээс аль хүссэнээ сонгож болно. Дэлхийд алдартай олон төрлийн хүнсний бүтээгдэхүүн энд бий.

Девид: Үнэ нь ямар вэ? Дэлгүүрээс арай хямдхан уу?

Бат: Ер нь гайгүй. Бөөнөөр нь авбал бүр сайн хямдарна.

Жюли: Бид маргааш өглөө «Далай ээж» зах руу явмаар байна.

Дэлгэрмаа: Та нар «Далай ээж» зах руу очингоо «Монгол ном»-ын дэлгүүрт ороод яваарай. Надад Алтангэрэлийн «Монгол-англи толь» нэгийг аваарай.

Девид: За болноо болно.

DELGERMAA: *Compared with before, food supplies in Ulan Bator have improved. Now one can buy anything at all.*

JULIE: *Which is the best food market?*

BAT: *In Ulan Bator there are many food markets, the 'Four Mountains', the 'Sea Mother', the 'Karakorum'. But they say that the 'Sea Mother' market is the best.*

DAVID: *Where is the 'Sea Mother' market?*

DELGERMAA: *The 'Sea Mother' market is south of the state department store, on the west side of the state circus.*

JULIE: *Why do they say this market is good?*

BAT: *The foreigners who live in Ulan Bator very much like to visit this market and buy their foodstuffs there. This is because the choice is good as to foodstuffs. For example, from all sorts of meat and milk products, fruit, vegetables, all kinds of sweets and jams, you can choose which you want. There are all kinds of world famous food products there.*

DAVID: *What are the prices like? Is it a bit cheaper than the shops?*

BAT: *Actually not bad. If you buy in bulk there are good reductions.*

JULIE: *We would like to go to the 'Sea Mother' market tomorrow morning.*

DELGERMAA: *While you're on your way to the 'Sea Mother' market please drop in at the 'Mongol Book' shop. Please buy me a copy of Altangerel's Mongol-English dictionary.*

DAVID: *Certainly.*

ШИНЭ ҮГ Vocabulary

| | | | |
|------------------|-----------------|---------|-----------------|
| бөөнөөр | bulk, wholesale | сайтай | good as to |
| бүтээгдэхүүн | product | сонголт | selection |
| гайгүй | not bad | сонгох | to choose |
| дуудах | to call | толь(н) | dictionary |
| дэлхийд алдартай | world-famous | хангамж | supply |
| ер нь | actually | хямдрах | to reduce price |
| жигнэмэг | jam | цирк | circus |
| жишээлбэл | for example | чихэр | sweets |
| зах | market | | |

Language points

New constructions

Delgermaa says: Улаанбаатарт нэг үеэ бодвол хүнсний хангамж их сайн болжээ. As бодвол ('if you reckon', conditional converb of бодох) can mean 'compared with' and нэг үеэ бодвол means 'compared with one (i.e. earlier) time', the sentence reads: 'Compared with before, food supplies in Ulan Bator have greatly improved (become very good).' Delgermaa continues: Одоо юу л бол юу авч болохоор байна. Here юу л бол юу is the object of the verbal construction and means 'anything at all', while авч болохоор байна (the verbal noun болох 'to become' plus the instrumental case ending) indicates how things have turned out: 'Now one can buy anything at all.'

Attributive nouns and fleeting n

When nouns describing substances or materials are used attributively fleeting n will appear (see page 56). Further examples:

| | |
|-------------------|-------------------------------|
| махан хоол | meat dish (мах) |
| сүүн бүтээгдэхүүн | milk products (сүү) |
| модон эдлэл | wooden goods, furniture (мод) |
| морин хуур | horse(head) fiddle (морь) |

However, an attributive fleeting n is sometimes coined for words which don't have it: үүрэн утас 'cell phone' (үүр), and even for

Russian words: бетонон гарааш 'concrete garage' (бетон), пластмассан цонх 'plastic window' (пластмасс), etc.

Taking the opportunity to do something -нгаа

This is a form of the verb which suggests that a person should take advantage of one action to do another. The subjects of the two clauses have to be the same. This so-called 'opportune' converb is formed with the suffix -нгаа (-нгоо, -нгөө, -нгээ):

Та зах руу очингоо дэлгүүрт ороод яваарай!
While you're on your way to the market call in at the shop.

Би банк руу явангаа Сүхийнд очмоор байна.
As I'm going to the bank I'd like to call on the Sükhs.

Telephone numbers

Six-figure numbers are spoken as three groups of double figures XX-XX-XX, and five-figure numbers as XX-X-XX:

Мон-Кор такси компаний утас нь 314299 (гучин нэг дөчин хоёр ерэн ес), Монгол такси компаний утас 55355 (тавин тав гурав тавин тав).

НЭМЭЛТ ҮГ

Additional vocabulary

Russian words in common use

Mongolian has acquired from Russian many everyday words as well as technical and political vocabulary. Several have already appeared in earlier lessons (касс, очир, автобус, торт). Often they describe clothing, furniture, food, etc. introduced into Mongolia during the period of Russian influence:

CLOTHING:

| | | | |
|-------------------|-------------|---------|--------------|
| костюм | suit, dress | пиджак | coat |
| сорочик (сорочка) | shirt | туфли | shoes |
| ботинк (ботинки) | boots | платье | dress, frock |
| брюк (брюки) | trousers | чемодан | suitcase |
| карман | pocket | размер | size |
| | | куртка | jacket |

Most words beginning with the letters **к, п, р** and **ф** have come from Russian, but they have acquired Mongol pronunciation and in some cases their spelling has changed. Note that **парк** can mean 'park' e.g. **зоопарк**, but that **автопарк** means 'vehicle fleet'.

HOUSEHOLD:

| | | | |
|----------------------|---------------------------------|------------------|--------------|
| плитк (плитка) | hotplate, cooker | хийн баллон | gas cylinder |
| кострюль (кастрюля) | saucerpan | ванн (ванна) | bathtub |
| мебель | furniture | кресло | armchair |
| приставк (приставка) | video recorder | гарааш (гараж) | garage |
| подъезд(н) | entrance hall, lobby (flats) | розетк (розетка) | socket |

The Mongolians have made a joke of the word **коньяк** on the basis that it consists of two Russian words **конь** 'horse' and **як** 'yak' and can therefore be translated into Mongolian as **морь сарлаг**.

| | | | |
|------------------|----------|---------|-------------|
| варень (варенье) | jam | салат | salad |
| печень (печенье) | biscuits | консерв | canned food |
| шампунь | shampoo | прокат | hire |

Other points

Like the present-future verbal noun **бичихээ** (Dialogue 1), the reflexive (accusative case) is used with the perfective verbal noun: **-гээс аль хүссэнээ сонгож болно**. This means that from among the foregoing list of items (the last having the ablative suffix) one could chose whichever (**аль**) one wished (**хүссэнээ**). Note **аль нь** 'which of them?' in **Хамгийн сайн аль нь вэ?** 'Which of them is the best?' and **... хамгийн сайн нь** '... is the best of them.'

Exercise 4

Answer the questions in Mongolian:

- 1 Улаанбаатарын хамгийн сайн хүнсний зах аль нь вэ?
- 2 «Далай ээж» хаана байдаг вэ?
- 3 Яагаад энэ зах сайн гэж?
- 4 Үнэ нь дэлгүүрээс арай хямдхан уу?
- 5 «Далай ээж» зах руу яаж явах вэ?

Exercise 5

Translate into Mongolian:

- 1 While you're in the shop buy some bananas.
- 2 The foreigners living in Ulan Bator like to go to that shop and buy their drinks there.
- 3 You can choose what (which) you want from all sorts of furniture there.
- 4 On the way to Mongolia I would like to spend two nights in Moscow.
- 5 What is your phone number? My phone number is 474339.

Exercise 6

Translate the following text into English:

Их дэлгүүрийн 1-р давхарт хүнсний бараа байдаг. Би өнөөдөр өглөө талх, сүү, мах, элсэн чихэр авсан учир тэндээс юм авсангүй. Харин 2-р давхарт гарч эрэгтэй хүний хувцасны тасагт очиж нэг улаан цамц үзлээ. Би кассанд мөнгөө өгөөд худалдгчаас цамцаа авлаа. Их дэлгүүрийн 3-р давхарт эрэгтэй, эмэгтэй хүний янз бүрийн хувцас бий. Би гуравдугаар давхарт гарсангүй. 1-р давхарт буулаа. Намайг тэндээс гарч явахад таван цаг болж байв. Гадаа тэнгэр сайхан байлаа. Би гэртээ хариад, шинэ цамцаа өмсөж, эхнэртэйгээ хамт кино үзэхээр кино театр луу явлаа.

Comprehension exercise: See how far you can follow this cartoon story, which illustrates the colloquial use of several verbs in **-чих-**, the imperative and the past perfect.

Key to cartoon on page 170

Би хүн мөн үү?

Am I really a man?

- 1 **Чи хүн шиг хичээж яваад картныхаа талхыг аваад ирж чадах уу? Чадна!**
Could you try like a man and go and buy our bread ration? Yes, I could!
- 2 **«Хүүхэд насанд хүргэж өгдөг галт тэрэг хэрвээ ...»**
'If there were a train taking one back to childhood ...' (words of a popular song)



- 1 Үхэр толгойлчихоод хүн дайрлаа гэм чи!
Having grown an ox's head you bumped into someone, you trouble!
- 2 Илжиг минь хөл дээр гишгэчихлээ!
(My) ass, you trod on my foot!
- 3 Заваан гахай минь хурдан мөнгөө өг!
(My) dirty pig, give me your money quickly!
- 4 Хулгайч муур царайлчихаад, хурдан аваад зайл!
(You) have taken on the looks of a thief cat, take (it) quickly and clear off!
- 5 Ээж ээ! Би хүн шиг явж чадсангүй!
Mummy! I wasn't able to go like a man!

| | | | |
|-----------|------------------|-------------------------------------|-------------------------|
| мөн | really am/is/are | карт(н) | ration card |
| гэм | trouble | илжиг | ass, donkey |
| заваан | dirty | хулгайч | thief |
| чадах | to be able to | хичээх | to try |
| зайлах | to clear off | хүргэж өгөх | to (help) take, deliver |
| муур | cat | дайрах | to bump into |
| толгойлох | to form a head | (толгойлчих to form a head quickly) | |
| гишгэх | to tread | (гишгэчих to tread suddenly) | |
| царайлах | to look like | (царайлчих to suddenly look like) | |

There was food rationing for a brief period in the early 1990s.

Dialogue 3

*Арай чанар муутай учраас
Because the quality is less good*

David and Julie go shopping in the market.

- Жюли: Энэ усан үзэм ямар үнэтэй вэ?
1-р Худалдагч: Усан үзэм наймтай (найман зуун төгрөг) байх шив дээ.
Жюли: Арай хямдхан байна уу?
1-р Худалдагч: Байна, харин хятадынх.
Девид: Хятадынх гэдэг чинь юу гэсэн үг вэ?
1-р Худалдагч: Хятадынх болохоор арай чанар муутай байдаг гэдэг юм. Тийм учраас арай хямд байгаа юм.

- Девид: За тийм бол үнэтэй нь дээр биз ээ. Надад нэг килийг өгөөч.
- Жюли: Та сайн үзэж аваарай. Долоо хэмжиж, нэг огтол гэж монголын сайхан үг байдаг юм.
- Девид: Өө за, баярлалаа. Харин тийм шүү.
- Жюли: Та мартуузай!
- 1-р Худалдагч: За найман зуун төгрөг өгөөрэй.
- Жюли: Баярлалаа. Баяртай.
- Девид: Би ТҮЦ (түргэн үйлчилгээний цэг)-ээс янжуур авмаар байна. Нэг «Камел» янжуур, нэг шүдэнз өгөөч. Ямар үнэтэй вэ?
- 2-р Худалдагч: Есөн зуун төгрөг. Шүдэнз хорин төгрөг. Бүгд есөн зуун хорь.
- Жюли: Нэг лааз «Фанта» өгчих.
- 2-р Худалдагч: «Фанта» долоон зуун төгрөг.
- Жюли: За май энэ таван мянган төгрөгний дэвсгэрт.
- 2-р Худалдагч: Хариулт мөнгөө аваарай. Гурван мянга гурван зуун наян төгрөг.
- Жюли: За баярлалаа.
- JULIE: *How much are these grapes?*
- SELLER 1: *Grapes are eight (hundred tugriks).*
- JULIE: *Are there any cheaper (ones)?*
- SELLER 1: *Yes, but they're Chinese.*
- DAVID: *What do you mean, Chinese?*
- SELLER 1: *It means that because they're Chinese the quality is less good ('more bad'). That's why they're cheaper.*
- DAVID: *In that case ('if that's how it is') the expensive ones are certainly better. Let me have ('give me') a kilo.*
- JULIE: *Take a good look before you buy. There is a nice Mongolian saying: 'Measure seven times before you cut.'*
- DAVID: *Oh well, thanks. You can say that again!*
- JULIE: *Mind you don't forget!*
- SELLER 1: *So that's ('please give me') 800 tugriks.*
- JULIE: *Thank you. Goodbye.*
- DAVID: *I want to buy some cigarettes at the 'fast service point' (kiosk). A (packet of) Camel cigarettes and a (box of) matches. How much is that?*
- SELLER 2: *900 tugriks. The matches are 20 tugriks. Altogether 920.*

- JULIE: *Let me have a can of Fanta.*
- SELLER 2: *Fanta is 700 tugriks.*
- DAVID: *Here, take this 5,000 tugrik note.*
- SELLER 2: *Here's your change, 3,380.*
- JULIE: *Ah, thank you.*

ШИНЭ ҮГ Vocabulary

| | | | |
|---------------|-------------|--------|-----------------|
| дэвсгэр | banknote | ХЭМЖИХ | to measure |
| лааз(н) | can, tin | ЦЭГ | (sales)point |
| огтлох | to cut | ЧАНАР | quality |
| түргэн | quick, fast | ШИВ | final, emphatic |
| усан үзэм | grape(s) | ШҮДЭНЗ | match(es) |
| хариулт мөнгө | change | ЯНЖУУР | cigarette(s) |

Language points

Admonitory form of the verb -уузай

Julie says to David, **Та мартуузай** 'Mind you don't forget!' The suffix **-уузай** (-үүзэй) is added to the stem (in this case, of **мартах** 'to forget'). Other possible translations include 'Make sure you're not ...', 'Make sure you don't ...' or 'Be sure not to (be) ...'

Юмаа мартуузай! Don't forget your things!

Verbal noun plus dative/locative: 'when'

'When' may be translated by adding the dative/locative case ending (appropriate vowel plus -д) to verbal nouns: **байх-ад** 'when being'. The tense is governed by that of the final verb. Where the two clauses have different subjects, as we have seen one of them is given the accusative case ending:

Намайг бага байхад манайх хөдөө байсан.

When I was little, my family lived (were) in the country.

Батыг гэртээ очиход Дэлгэрмаа байхгүй байсан.

When Bat went home, Delgermaa wasn't there.

If the subject of both clauses is the same, a reflexive ending is added to the verbal noun after the dative/locative suffix, e.g.

Бат гэртээ харихдаа хурдан явсан.
When Bat went home he walked quickly.

оюутан байхдаа when/while a student.

Similarly: **оюутан байхаасаа** since becoming a student

Vowels in Russian words

In Russian words stress is unmarked and irregular. The Russian for 'garage' (**гараж**), stressed on the second syllable, is written **гарааш** in Mongolian. The spelling of words of Russian origin in Mongolian often does not conform to the Mongolian rule that front and back vowels do not mix in the same word. For example, the word **курс** meaning 'course' seems to be a back-vowel word but takes the plural suffix **-үүд** used with front-vowel words: **курсүүд**, **курсүүдийн** 'of the courses', etc. Compare this with the word **курд** 'Kurd(ish)' which has the regular plural **курдууд(ын)**. Similarly **музей** 'museum' forms the plural **музейнүүд**.

Another example of mixed vowels is found in **Крымийн татаарууд** 'Crimean Tartars'. In Mongol words the letter **ы** appears only in the accusative and genitive back-vowel suffixes. The Khanate of Crimea, founded in 1443 as one of the successor states of the Mongols' Golden Horde, became a vassal of the Ottoman Turks in 1475 and the Crimean Tartars were gradually Turkicised. The Crimea was annexed to Russia by Catherine the Great in 1783.

Some Mongolians consider that the words **крым** and **кремль** (Kremlin) were both originally Mongol, derived from 'kerem' meaning wall or citadel (in modern Mongol **хэрэм** – the Great Wall of China is called **цагаан хэрэм**). The white limestone walls of the original Moscow Kremlin were built in 1367 and attacked by the Mongols in 1382. The Crimean Tartars tried twice to capture Moscow, in 1571 when they destroyed everything except the Kremlin, and in 1591 when their attack failed.

Сар шинийн баярын үйлчилгээ

Хүнсний болон барааны захууд **Эмийн сан**
«Алтай ээж», «Дөрвөн уул» зэрэг «Алтай» (хуучнаар 34 дүгээр эмийн
хүнсний битүү зах хоёрдугаар сан), «Эрдэнэ бүрэн» (Төмөр
сарын 7-нд 10–19 цагуудад замын коллежийн баруун урд талд
ажиллаж, 8, 9-нд амарна, 10-наас байрладаг), «Нахиа» (хуучнаар 15
өдрийн цагийн хуваарьт орно. дугаар эмийн сан), «Наран туул»
Хүнсний «Хүчит шонхор», барааны (хуучнаар 3 дугаар эмийн сан)
төн зах, «Хар хорин», техникийн эмийн сангууд 24 цагаар ажиллана.
«На хүрээ» зэрэг задгай зах

хоёрдугаар сарын 7-нд 10–17 **Нийтийн хоол**
цагуудад ажиллаад, 8, 9, 10, 11-ний Нийтийн үйлчилгээтэй хоолны
өдрүүдэд амарч, 12-ноос өдрийн газрууд хоёрдугаар сарын 8, 9-нд
цагийн хуваариар ажиллаж эхэлнэ. амарч, бусад өдрүүдэд өдрийн
цагийн хуваариар ажиллана.

Гэр хорооллын усны хангамж
Гэр хорооллын ус түгээх байрууд гуанз, цайны газрууд түшиглэсэн
хоёрдугаар сарын 7, 10-нд 10–14, газрынхаа ажиллах цагийн
16–20 цагуудад ажиллаж, 8, 9-нд хуваарийг мөрдөнө.

амарна. Бусад өдрүүдэд өдрийн **Дулааны хангамж**
цагийн хуваариар үйлчилнэ. Гэр Дулааны шугам сүлжээний газрын
хороолол болон орон сууц, диспетчер, хариуцлагатай жижүүр
үйлчилгээний газрын усны 24 цагаар ажиллаж, дулаан
хангамжтай холбогдсон санал, хангамжтай холбогдсон санал,
хүсэлтийг Ус сувгийн ашиглалтын хүсэлтийг 343047, 342978 дугаарын
сарын 452730, 450208 дугаарын утсаар хүлээн авна. утсаар хүлээн авна.

Худалдаа **Нийтийн тээвэр**
Хоёр ээлжтэй хүнсний дэлгүүрүүд Автобус, троллейбус хоёрдугаар
хоёрдугаар сарын 8-нд амарч, 9, 10, сарын 7-нд 7–22.30, 8, 9-ний
11, 12-нд 10–17 цагуудад ажиллана. өдрүүдэд 8-22.30 цагуудад
Нэг ээлжтэй хүнсний дэлгүүрүүд 8, үйлчилнэ. Хоёрдугаар сарын
9-нд амарч, 10, 11-нд 9–17 цаг 10-наас өдрийн хуваариар
хүртэл ажиллана. 24 цагийн ажиллана. Такси хоёрдугаар сарын
үйлчилгээтэй хүнсний дэлгүүрүүд 7-нд 7–23, 8, 9-нд 9–23 цаг хүртэл
амрахгүй. Аж үйлдвэрийн барааны ажиллаж, 24 цагаар дуудлага
дэлгүүрүүд 8, 9-нд амарна, 10-нд хүлээн авч үйлчилнэ.
10–17 цагт ажиллаж, 11-нээс
өдрийн хураариар ажиллана.

НЭМЭЛТ ҮГ

Additional vocabulary

| | | | |
|----------|-----------------|------------|-----------------|
| битүү | closed; covered | түгээх | to distribute |
| гуанз(н) | restaurant | түшиглэх | to depend on |
| задгай | open, open-air | хариуцлага | responsibility |
| нахиа | bud | холбогдох | to be connected |
| санал | opinion, view | хүсэлт | request |
| суваг | channel | шугам | line, route |
| сүлжээ | network, system | ээлж | shift, turn |

Сар шинийн баяр: operating hours of markets, pharmacies, shops and services over the new-year holiday or **цагаан сар**. The Russian **диспетчер** (from the English 'despatcher') means 'controller'. See Exercise 9 for comprehension practice.

Other points

The expression **харин тийм шүү** 'but certainly' means 'You can say that again!' or 'You've said it!' Note also the terms **хариулт мөнгө** 'change', 'answer money' and **задгай мөнгө** 'small change'.

Exercise 7

Translate into Mongolian:

- 1 Mind you don't drink any vodka! Mind you don't fall asleep!
- 2 When I was small I used to live in London.
- 3 When I went into the hotel my wife wasn't there.
- 4 Mongolia is a country worth visiting.
- 5 In winter the mountains are a place one shouldn't go to.

Exercise 8

Translate the text into English:

Хандаа хоёр ногоон харандаатай байжээ. Түүний найз Буян охинд ногоон харандаа нэг ч байсангүй. Буян охин:

—Ногоон харандаагаа надад нэг өгөөч гэхэд Хандаа,

—Ээжээс асуучихаад өгье гэв. Маргааш нь хичээлийн завсарлагаар тэр хоёр дахин уулзаад Буян:

—Ээж чинь юу гэж байна? гэж асуув. Хандаа,

—Ээж ч өг л гэж байна. Ахаасаа асуусангүй дээ гэв. Буян:

—За яах вэ, ахаасаа асуугаарай гэв. (Үргэлжлэл бий)

Exercise 9

The chart on page 175 shows services available in Ulan Bator over the new-year holiday:

- 1 On which days will the food markets be closed?
- 2 On which days will the food shops be closed?
- 3 When will the trolleybuses run on 8th February?
- 4 Will *ger* districts have a water supply over the holiday?
- 5 Will flat dwellers be able to register a complaint about the heating and hot water supply?

Exercise 10

Translate the text into English:

Багш: Бид хониноос юу авч ашигладаг билээ?

Сурагч: Ноос.

Багш: Зүйтэй. Ноосоор юу хийдэг билээ?

Сурагч: Мэдэхгүй.

Багш: За тэгвэл, чиний пальтог юугаар хийсэн юм бэ?

Сурагч: Аавын хуучин пальтоогоор хийсэн.

Exercise 11

The chart on page 179 shows train services from Ulan Bator:

- 1 On which days can you catch the No. 6 train for Moscow?
- 2 When does the Moscow-Beijing train leave Ulan Bator?
- 3 What other train services are there from Ulan Bator to Moscow and Beijing?
- 4 When does the train from Baganuur leave for Ulan Bator?
- 5 In which direction is No. 212 train an overnight service?

Dialogue for comprehension 8 

Бат: За хоёулаа юу юу авах билээ?

Дэлгэрмаа: Чамд авах юмны жагсаалт байгаа.

Бат: Би хараадахъя. Цай, чихэр, гурил, жаахан гахайн

мах, төмс, улаан лууван, улаан лооль, ааруул гэж байна. Аа бас хуруун зай хэрэгтэй юм байна. Манай гар чийдэнгийн зай саяхан дуусчихсан. Манайд талх бий юү?

Дэлгэрмаа: Байхгүй. Өчигдөрийн талх дууссан. Бас хагас кило сайхан усан үзэм нэмж авъя.

Бат: Тэгье, тэгье. Усан үзэм их үнэтэй байна шүү. Нэг кило нь нэг мянга долоон зуун төгрөг гэж байна.

Дэлгэрмаа: Хэдэн төгрөг болж байгаа бол?

Кассчин: Таван мянга гурван зуун наян төгрөг.

Бат: За баярлалаа. Баяртай.

Кассчин: Баяртай. Манайхаар дахиад үйлчлүүлээрэй.

Бат: «Нарантуул» барааны зах хол биш. Зах руу хамт явъя.

Дэлгэрмаа: Тэгье. Би шинэ малгай авмаар байна. Энэ сайхан малгай ямар үнэтэй вэ?

Худалдагч: Хорин мянган төгрөгнөөс ярина.

Дэлгэрмаа: Та үнээ жаахан татахгүй юү?

Худалдагч: Жаахан татаж болно шүү. Та хэдээр авмаар байна?

Дэлгэрмаа: Арван зургаан мянгаар авъя.

Худалдагч: Арай бага байна. Арван найман мянгаар ав.

Дэлгэрмаа: Арай үнэтэй байна. Арван долоон мянгаар авъя.

Худалдагч: За, за, ав, ав.

Дэлгэрмаа: Би гэртээ харилаа. Ядарч байна. Та «Далай Ээж» зах руу очингоо «Монгол Тээвэр» компаниар ороод ирээрэй. Бидэнд Өвөрхангай аймаг руу явах автобусны цагийн хуваарь хэрэгтэй байна. Та мартуузай!

| | | | | | |
|-------|---------|----------------|--------|-------|-----------|
| гурил | flour | (улаан) лууван | radish | татах | to reduce |
| зай | battery | гар чийдэн(г) | torch | | |

For the attention of railway passengers (see p. 179):

Apart from the below-mentioned trains, no changes have been made to the timetable (for other trains).

| | | | |
|--------------|-----------------|----------|-----------|
| ачаа-суудлын | goods-passenger | өөрчлөлт | change |
| дээр дурдсан | above-mentioned | масштаб | map scale |

Галт тэргээр зорчигчдын анхааралд

1. Бээжин - Улаанбаатар - Москвагийн чиглэлд явах 3 дугаар галт тэрэг 6 дугаар сарын 12-ноос эхлэн Улаанбаатарт Пүрэв гаригийн 13, 16 цагт ирж, 13.50 цагт явна. Москва - Улаанбаатар - Бээжингийн 4 дүгээр галт тэрэг 6 дугаар сарын 8-наас эхлэн Улаанбаатарт Ням гаригийн 7.38 цагт ирж, 8.08 цагт явна.

2. Улаанбаатар - Бээжингийн хооронд явах 24/23 дугаар галт тэрэг 6 дугаар сарын 12-ноос эхлэн Улаанбаатараас Пүрэв гаригт 8.08 цагт явж, Бээжинд Баасан гаригийн 15.33 цагт очоод Бээжингээс 5 дугаар сарын 20-ноос эхлэн Мягмар гаригийн 7.40 цагт явж, Улаанбаатарт Лхагва гаригийн 13.16 цагт ирнэ.

3. Москва - Улаанбаатарын 6 дугаар галт тэрэг 6 дугаар сарын 9-нөөс эхлэн Улаанбаатарт Даваа, Мягмар гаригийн 7.38 цагт ирж, Улаанбаатараас Даваа, Бямба гаригийн 11.20 цагт явна.

4. Улаанбаатар - Дарханы хооронд явах 212 дугаар галт тэрэг 6 дугаар сарын 6-наас эхлэн өдөр бүр Дарханаас 22.20 цагт явж, Улаанбаатарт 5.30 цагт ирнэ. 211 дүгээр галт тэрэг Улаанбаатараас 15.50 цагт явж, Дарханд 20.25 цагт очно.


5. Улаанбаатар - Замын-Үүдийн хооронд явах 276 дугаар галт тэрэг Улаанбаатараас 12.33 цагт явж, Замын-Үүдэд 6.03 цагт очоод, Замын-Үүдээс 18.45 цагт явж, Улаанбаатарт 10.07 цагт ирнэ.

6. Улаанбаатар - Багануурын чиглэлд явах 278/277 дугаар галт тэрэг Улаанбаатараас долоо хоногийн Мягмар, Лхагва, Пүрэв, Бямба, Ням гаригийн 16.30 цагт явж, Багануурт 20.54 цагт очоод, Багануураас 3.02 цагт явж, Улаанбаатарт 7.30 цагт ирнэ. Улаанбаатар - Чойрын чиглэлд явах 282 дугаар галт тэрэг Улаанбаатараас долоо хоногийн Даваа, Баасан гаригийн 16.30 цагт явж, Чойрт 21.25 цагт очоод, Чойроос 2.25 цагт явж, Улаанбаатарт 7.30 цагт ирнэ.

7. Дархан - Шарын голын хооронд явах ачаа-суудлын галт тэрэг Дарханаас 18.10, 5.40 цагт явж, Шарын голд 20.40, 8.10 цагт очоод, Шарын голоос 22.00, 9.30 цагт явж, Дарханд 00.13, 11.43 цагт ирнэ.

8. Эрдэнэт - Дарханы хооронд явах 313 дугаар галт тэрэг Эрдэнэтээс Даваа гаригийн 14.02 цагт явж, Дарханд 17.58 цагт ирнэ.

Дээр дурдсан зорчигчдын галт тэрэгнээс бусад галт тэрэгний цагийн хуваарьт өөрчлөлт ороогүй.



9 Өргүй бол баян, өвчингүй бол жаргал

**Having no debt is wealth and no
illness happiness**

In this lesson you will learn:

- About the 'three manly sports'
- Decimals and fractions
- Parts of the body and seeing a doctor
- About a business exhibition

Dialogue 1

**Эрийн гурван наадам
The three manly sports**

Bat and Delgermaa tell David and Julie about 'naadam' and the 'three manly sports' of wrestling, archery and horse racing.

- Девид: Монгол оронд хамгийн их дэлгэрсэн спорт юу вэ?
- Дэлгэрмаа: Бөх барилдах, сур харвах, морь уралдах. Энэ гурвыг эрийн гурван наадам гэдэг юм. Наадам жил бүр долдугаар сард болдог. Та үзээгүй биз дээ?
- Девид: Үгүй, яаж үзэх вэ? Би Улаанбаатар хотод долдугаар сард байдаггүй.
- Дэлгэрмаа: Төв цэнгэлдэх хүрээлэнд Монголын тулгар төр байгуулагдсаны 790, Ардын хувьсгалын 75 жилийн ойн их наадам болсон. Уламжлал ёсоор улс аймгийн алдар цолтой 512 бөх зодоглосон.

Бат: «Ардын Эрх» сонинд «Хүчит бөхийн барилдааны нэгийн даваа эхлэхэд зүүн талын магнайд Монгол Улсын хөдөлмөрийн баатар, даяар дуурсагдах далай даян дархан аварга Баянмөнх гарав. Гурвын даваанд таван аврага, нэг арслан барилдав» гэж бичсэн байна.

Дэлгэрмаа: Наадмын эхний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч сурын харвааг сонирхож, харваачидтай уулзав. Нийслэлийн Хан-Уул дүүргийн залуу харваач Даваажаргал 36 сумандаа 32 онож түрүүлэв.

Бат: «Ардын Эрх» сонинд «11-ний өглөө эрт Айдасын давааны овоог нар зөв тойроод 630 шахам хурдан азарга гарааны зурхай тийш хөдөллөө. Хурдан азарганы түрүү магнай сартай хамар цагаан хонгор 24,6 (хорин дөрөв аравны зургаа) км замыг 33,28 (гучин гурав зууны хорин найм) минутад туулжээ» гэж бичжээ.

Девид: Би бас монгол хурдан морь унамаар байна!

DAVID: *Which are the most popular sports in Mongolia?*

DELGERMAA: *Wrestling, archery and horse racing. These three are called the three manly sports. The naadam is held every year in July. Haven't you seen it?*

DAVID: *No, how could I (see it)? I am never in Ulan Bator in July.*

DELGERMAA: *There was a big naadam in the central stadium on the 790th anniversary of the founding of the newly established Mongolian state and the 75th anniversary of the people's revolution. In accordance with tradition 512 wrestlers with national and provincial ranks and titles put on their wrestler's jackets.*

